

**МОНГОЛ ДАХЬ ТӨЛӨӨЛЛИЙН БА ШУУД АРДЧИЛЛЫН АСУУДАЛ  
ТҮҮНД ТУЛГАРЧ БАЙГАА БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

**С.БАЗАРПҮРЭВ**

*Профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим*

**У.БАТЦЭРЭН**

*Улс төр судлалын тэнхимийн докторант*

**Түлхүүр үг:** Ардчилал, шууд ба төлөөллийн ардчилал, парламент, гүйцэтгэх засаглал, иргэний нийгэм, иргэдийн улс төрийн оролцоо, улс төрийн нам, улс төрч, сонгууль.

**Товч утга:** Ардчиллын нийтлэг хэлбэр болох шууд ба төлөөллийн ардчилал нь харилцан холбогдож, бие биенээ нөхөн сэлбэж байдаг. Монгол оронд 1990 оноос хэрэгжиж буй ардчилсан өөрчлөлтийн үйл явцад ардчиллын дээрх хоёр хэлбэрийн харьцаа алдагдаж, шууд ардчилал гэхээсээ төлөөллийн ардчиллыг ардчиллын боломжтой, зохистой хэлбэр хэмээн үзэж ирсэн. Үүний уршгаар иргэдийн улс төрийн оролцоо тэр дундаа төлөөллийн болон шууд ардчиллын давуу болон үр өгөөжтэй талууд нь саармагжин үгүйрч, нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр судлалын салбараас “Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо” сэдэвт суурь судалгааны төслийн хүрээнд шинжээчийн санал асуулга явуулан уг асуудлыг судлан түүний үр дүнд үндэслэн дээрх сэдвийн хүрээнд тухайн асуудлыг авч үзэхийг зорив.

\* \* \*

Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд “Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэсэн ч уг заалт нь цөөнгүй асуудал дагуулан бэрхшээл, гажуудал бий болгож байна.

Иргэдийн шууд сонгосон гишүүдийг Улсын Их Хурлын байнгын хороонд ялгаварлан хувнарлаж, нийгмийн зарим хэсэгийнхний сонгосон гишүүнээрээ дамжуулан үзэл бодол, байр суурна илэрхийлэх учиртай эрх нь хязгаарлагдлаа гэж үзэж болно. Улсын Их Хурлын гишүүд нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх тэгш эрхээ олж авч чадахгүй байхад ард түмнийг адилхан эрхтэй, ардчилсан нийгэмд байна гэж үзэх үндэс нэн багатай.

Төлөөллийн болон шууд ардчиллын язгуур утга нь иргэдийн улс төрийн оролцоо юм. Төлөөллийн ардчилал нь төлөөллийн, шууд ардчилал нь шууд оролцоонд суурилдаг. Иргэдийн оролцоо бодитой хангагдаж байж гэмээн ардчилал амьд бөгөөд хүч нөлөөтэй байдаг. Иргэдийн оролцоо хомс байгаа газар ардчилал ёс төдий оршиж байдаг. Орчин үед “оролцоот ардчилал”-ын тухай сэдэв ихээхэн анхаарагдах болов. Судлаачдын зарим нь оролцоот ардчиллыг “оролцоот улс төр” хэмээн томъёолж байна. Ардчилал нь иргэдийн улс төрийн оролцоогоор зохион байгуулагдан хөгждөг. Иргэдийн улс төрийн оролцоо нь иргэний нийгмийн оршин байх тулах цэг нь болж өгнө гэсэн суурь томъёололттой чөлөөт ба иргэний тэгш өргөн оролцооны ардчилалын (participatory democracy) үзэл баримтлал ХХ зууны 60-70-аад оны үеэс дэлгэрэх болсон. Ж.Руссогийн “төлөөллийн ардчилал”, “төлөөллийн засаглал” хэмээх томъёолол зайлшгүй байх ёстой үзэл баримтлал болон олон зууны турш баяжин хөгжиж ирсэн. Ардчиллын сонгодог онолч Ж.Милль “нийт ард түмэн төрийн дээд эрх мэдлийн системд тэгш оролцдог болохоос илүү зүйл үгүй. Чухам энэ л ардчилсан засаглал болно” гэж хэлж байсан. Тэгвэл төрийн эрх мэдлийн системд нийт ард иргэдийн төлөөлөл тэгш бус оролцдог болсон өнөөгийн манай улсын нөхцөл ардчиллын сонгодог онолчийн үзэл баримтлалаар ардчилсан биш болон хувирч байна. Ардчиллын өөр нэгэн төлөөлөгч Р.Даль “зөвхөн ардчилсан засаглал л төлөөллийн, улс төрийн тэгш эрхийн харьцангуй өндөр түвшинг хангаж чадна. Ардчилалд татагдаад байгаагийн нэг гол шалтгаан нь энэ байгуулал иргэдийн тэгш эрхийг улс төрийн өөр системийн нөхцөлөөс хавьгүй илүүтэйгээр хэрэгжүүлдэгт оршино” гэж тайлбарласан. Тухайн дүгнэлттэй Монголд байгаа засгийн шинж чанар

нийцэхгүй байгаа нь ардчилалд учирч буй асуудал, бэрхшээл их байгааг харуулж байгаа тул хамтын бүтээлд төлөөллийн ардчилалын гол хэлбэр болох парламентын асуудлыг голлон авч үзэв.

Төлөөллийн ардчиллын гол хэлбэр болох парламент чадамжгүй байгаа нь өнөөдөр нүүрлээд байгаа бодит үнэн юм. Засгийн газар төрийн бодлого тодорхойлоход давамгайлах хандлага газар авч, гадны хүчин зүйлс улс төрийн шийдвэрт нөлөөлж, улс төрийн үйл явцад хяналт тавих чадваргүй, нийгмийн иргэдийн эрх ашиг сонирхлыг төлөөлөх парламент алга гэсэн байр суурийг нийгмийн гишүүдийн олонх нь илэрхийлэх болжээ. Улсын Их Хурал нь төлөөллийг хангасан, ил тод, нэвтрэх ба харилцах боломжтой, хариуцан тайлагнадаг, үр нөлөөтэй байж төлөөллийн ардчилал бодит утгаараа Монголд хэрэгжинэ.

Парламентын нэр хүнд иргэдийн дунд доогуур байдаг ч түүнийг өөд нь татах арга зам багагүй байгааг дэлхийн олон орны жишээ харуулж байна. Тухайлбал, бүрэлдхүүн, ажлын арга барилын хувьд оролцоог илүү сайн хангах, ялангуяа эмэгтэйчүүд, үндэсний цөөнх, гадуурхагдсан бүлгүүдийг хамруулах; үйл ажиллагаагаа хэвлэл мэдээлэлд илүү нээлттэй болгох, сахим хуудас, нэвтрүүлгийн суваг бий болгох замаар олон нийттэй илүү үр нөлөөтэй харилцагч болох; олон нийт, түүний дотор иргэний нийгэмтэй харилцах, тэдэнд хууль тогтоох ажиллагаанд хувь нэмэр оруулах боломж олгосон шинэ арга замыг турших; ёс зүйн дүрэм мөрдүүлэх, намын санхүүжилтийн шинэтгэлийг хэрэгжүүлэх замаар парламентын гишүүдийн шударга байдлын талаарх олон нийтийн итгэлийг сэргээх; хуулийн төсөл боловсруулахад тавих хяналтыг сулруулахгүйгээр хууль тогтоох ажиллагааг хялбаршуулах; гүйцэтгэх засаглал, түүний дотор улам бүр чухал болж буй гадаад бодлогын салбарт илүү үр нөлөөтэй хяналт тавих; олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд парламентыг оролцоог нэмэгдүүлэх, хүчирхийлэл, мөргөлдөөнийг шийдвэрлэх үүднээс үндэстэн дамнасан хамтын ажиллагаанд илүү идэвхтэй байх зэрэг эерэг хандлагыг бий болгохын төлөө ажиллаж байна.

Үүний зэрэгцээ манай улсын парламентын төлөөллийн ардчиллын практикийн чиг хандлага нь өнөөдөр парламентад тулгарч буй бүх асуудлыг томъёолон практикт хэрэгжүүлэхэд гарч байгаа бэрхшээл, гажуудал зэргийг зарим талаараа тодорхойлж байна. Нэг талаас, туйлын зорилго ба улс төрийн байгуулал, практикийн аль аль нь болохын хувьд ардчилал дэлхийн зарим нэг оронд ялаад байна. НҮБ-ын 2005 оны дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтаас “ардчилал бол аливаа нэг орон, бүс нутагт харьяагдах бус”, “түгээмэл үнэт зүйл” хэмээн мэдэгдсэн. Нөгөө талаас, энэ хугацаанд ардчиллын бодит үр дүнд итгэл алдарсан байдал ардчилал тогтоод удаж байгаа болон ардчиллыг шинээр тогтоож буй орны иргэдийн аль алиных нь дунд бий болжээ.

Италийн улс төрийн онолч Норберто Боббио “биелэгдээгүй амлалт” буюу “амлалт, ажил хэргийн зөрүү”-ний талаар сэтгэл алдрах явдал нь ардчиллын аливаа байгуулалд байнга оршоор ирсэн байж ч болох юм гэжээ. Ардчилсан орнууд аюулгүй байдал, эдийн засаг, иргэдийнх нь амьжиргаа, сайн сайхан байдалд нөлөөлж буй, мөн өөрсдийнх нь хяналтаас гадуур мэт санагдах хүчин зүйлийг шийдвэрлэх үүрэг хүлээж буй өнөө үед энэ ялгаа илүү анхаарал татаж байна.

Төлөөллийн ардчиллын гол байгууламж болох, парламент нь ард түмний хүсэл зоригийг илэрхийлж, ардчилал тэдний хэрэгцээг зүй ёсоор мэдэрч, өдөр тутмын амьдралд нь тулгарч буй хамгийн хүнд бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд тусална гэсэн иргэдийн хүлээлтийг тээдэг. Нийгмийн олон янзын хүмүүсийг төлөөлж сонгогдсон байгууллага. Парламент нь бүлэг, иргэдийн зөрчилдсөн сонирхол, хүлээлтийг яриа хэлэлцээ, зөвшилцлийн арга хэрэгслээр зохицуулахад онцгой үүрэг хүлээнэ. Парламент нь тухайн улс орны хууль тогтоомжийг түргэн өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд тааруулан тохируулах үүрэгтэй. Засгийн газарт хяналт тавих итгэмжлэгдсэн байгууллагын хувьд, парламент нь засгийн газрыг ард түмэнд хариуцан тайлагнуулах үүрэг хүлээнэ.

Сүүлийн жилүүдэд олон орны парламент сонгогчдоо илүү бодитой төлөөлөх; сонгогчиддоо хүрч ажиллах, тэдний өмнө хариуцан тайлагнах, дүрэм журмаа илүү нээлттэй, ил тод болгох, хууль тогтоох ба засгийн газарт хяналт тавих гол чиг үүргээ үр нөлөөтэй биелүүлэх зэргээр олон нийттэй үр нөлөөтэй харилцах, ажлын арга барилаа сайжруулахын тулд ихээхэн хүчин чармайлттай ажиллах болсон.

Парламент үндэсний уламжлал, онцлог шинж чанартай ч парламентууд хоорондоо туршлага солилцон, нийтлэг асуудлын боломжит шийдлийн талаарх бусдын санааг нөхцөл байдалдаа тохируулан ашиглах чармайлт хийж байна. Төлөөллийн ардчилал нь төлөөллийн байгууллага болон практикийн багцаар дамжин хэрэгжиж, цаг хугацааны явцад үүсэн бий болж, хувьсан өөрчлөгдсөөр байдаг. Үүнийг дагаад дараах асуудалд анхаарч шийдвэл зохих юм.

Иргэний нийгэм, иргэдийн оролцоо: Төлөөллийн ардчилал дахь иргэдийн үүрэг парламентыг сонгосноор дуусахгүй улмаар төр ард түмний хэрэгцээ шаардлагыг мэдэрч ажиллахыг хүсч байгаа л бол иргэд засгийн газартай байнга харилцаж байх хэрэгтэй болно. Иргэний нийгмийг дэмжиж, улс орны тулгамдсан асуудлын шийдлийг олох, хууль тогтоомжийн чанар, учир холбогдлыг сайжруулахын тулд нягт хамтран ажиллах нь

зүйтэй боловч үүнийг төр, засаг төдийлөн сайн дэмжиж ажилдаггүй.

Иргэний эрх: Хүмүүс өөрт хамаатай хууль, бодлогод ямар нэг байдлаар нөлөөлөхийн тулд тэдний өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх, бусадтай чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, чөлөөт, шударга сонгуулиар төлөөлөгчөө сонгох гэх мэт үндсэн эрх баталгаажсан байх ёстой байдаг. Өнөө үед хөгжилтэй болон хөгжиж буй орны олонхи иргэд эдийн засаг, нийгмийн эрх бол иргэний ба улс төрийн эрхтэй адил үндсэн эрхийн чухал хэсэг гэж үзэх болсон.

Эрх мэдэл ба засаглал: гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх гэсэн эрх мэдлийн уламжлалт хуваарилалтын дотор парламент нь чөлөөтэй сонгогддог байгууллага болохын хувьд аль ч ардчилсан улс оронд голлох байр суурийг эзэлдэг. Парламент бол ард түмний хүсэл зоригийг илэрхийлдэг, ард түмний засаглал практикт хэрэгждэг байгууллага юм. Ард түмний төлөөлөгчийн хувьд парламент нь засаглалын бусад салаа мөчир, олон улсын ба үндэсний янз бүрийн байгууллагатай тэднийг төлөөлж харилцана. Харин нөгөө нь, тэд эрх мэдлийн хуваарилалтын хүрээнд өөрт ноогдсон онцлог чиг үүргээ хэр үр нөлөөтэй хэрэгжүүлж байгаа тухай асуудал юм. Манай улсын хувьд зарим талаараа гүйцэтгэх засаглал нь парламентаасаа илүү эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа явдал нь төлөөллийн ардчилалд тулгараад буй олон бэрхшээлтэй асуудлуудын нэг юм.

Улс төрийн нам: парламент иргэдийг зөвхөн хувь хүмүүсийнх нь хувьд төлөөлдөггүй; бодлогын тодорхой чиг хандлагыг баримтлахын тулд улс төрийн намаар дамжуулан иргэдийг хамтад нь төлөөлдөг. Намууд сонгуульд сонголтыг нэгтгэн төвлөрүүлэх үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ уг сонголт парламентын ажил хэрэг, нийтийн хэлэлцүүлэгт тусгалаа олоход үйлчилж байдаг. Улс төрийн нам нь сонгогчдыг төртэй холбох гүүр нь болох учиртай. Монголд зарим нэгэн улс төрийн нам нь улс төр, эдийн засгийн нөөц боломжоо хууль бус замаар бий болгох нөхцөлийг бүрдүүлж байгаа нь төлөөллийн ардчилалд харшилж байгаа шийдвэрлэвэл зохих асуудал болоод байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл: төлөөллийн ардчилалд учираад буй өөр нэгэн гол бэрхшээлтэй, гажуудалтай асуудал бол олон нийтэд бодит байдалын талаар үнэн зөв мэдээллийг хүргэж чадахгүй байгаа явдал. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь төрийн ажлын талаар иргэдэд мэдээлэх гол хэрэгсэл, парламент олон нийттэй харилцах чухал суваг юм. Тэд энэ үүргээ хэр сайн гүйцэтгэж байгаа нь төлөөллийн болон шууд ардчилал төлөвшин бэхжихэд нэн ач холбогдолтой. Манай улсын хувьд засгийн газар нь хяналтыг гартаа авсан тогтолцоонд аль нэг талыг хэт барьж ажиллах эсхүл хэт арилжаажсан тогтолцоон дахь эдийн засгийн хүчирхэг сонирхлын улмаас энэ чиг үүрэг гажуудах болсон.

Парламент нь ард түмний санаа бодол, хэрэгцээг илэрхийлэн, шийдвэрлэх зорилго бүхий төлөөллийн байгууллага юм. Парламент нь хэлэлцэх ба харилцан буулт хийж зөвшилцөх гэсэн ардчиллын онцлог шинжийг агуулдаг ба хувь хүмүүс, хэсэг бүлгийн сонирхлын нийлбэрээс олон нийтийн ашиг сонирхол давуу хэрэгжих арга. Түүнчлэн парламент хууль тогтоох, төсөвт хяналт тавих, гүйцэтгэх засаглалыг хянах зэрэг үндсэн чиг үүргээ хэр үр нөлөөтэй хэрэгжүүлж байгаа нь ардчиллын чанарт чухал ач холбогдолтой. Энэ үүргээ хэрэгжүүлэхдээ парламент иргэний нийгэмтэй хамтран ажиллаж, иргэдийн эрхийг хамгаалах онцгой үүрэг хүлээнэ.

Шууд ардчиллын давуу талыг илрүүлэн ашиглах үндсэн дээр төлөөллийн ардчиллын зарим сул талыг нөхөх, тэдгээрийн байж болох зохистой харьцаа, зохицлыг хангах, иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж буй болно. Үүнтэй холбоотойгоор төлөөллийн ба шууд ардчилалд учирч буй асуудал, бэрхшээл, гажуудлыг тодорхойлон гаргахын тулд жишээ нь шинжээчдийн санал асуулгад “Таны бодлоор төлөөлийн ба шууд ардчилалд ямар гажуудал, бэрхшээл байна вэ?” гэсэн нээлтэй асуулгыг оруулж өгсөн.

Судалгаанд хамрагдсан шинжээчдийн 18.9 хувь нь буюу 4 хүн тутмын нэг нь төлөөллийн ардчилалд учирч буй гажуудал, бэрхшээлийг хариуцлага тооцох механизм үгүйлэгдэж байна мөн иргэдийн хяналт сул гэж хариулсан бол шууд ардчилалд учирч буй гажуудал, бэрхшээлийг нийгмийн ухамсар болон иргэдийн боловсрол дутмаг гэж 28.2 хувь нь буюу 3 хүн тутмын нэг нь хариулсан байна. Монгол Улсад хэрэгжиж буй төлөөллийн ардчилалын гажуудал, бэрхшээлийн талаар өгсөн шинжээчдийн саналыг товч дурдвал.

#### Шинжээчдийн санал

1. Популизм хөгжиж байна, нэр дэвшүүлэх процесс жинхэнэ төлөөллөөсөө гарахгүй байгаа байдал;
2. Улс төрчид ард иргэдийн бүрэн төлөөлөл болж чадахгүй байх, өрсөлдөөнт цөөнхийн элитийн төлөөлөл тогтсон байдал, улс төрийн намуудын нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хэрэгжихгүй байх, иргэд улс төрийн боловсрол сул байгаа нь төлөөллийн ардчиллын гажуудлыг үүсгэж байгаа байдал;
3. Сонгогч нэг бүрийн санал бүрэн төлөөлөгдөх боломж сул, сонгогчдын өмнө хүлээх хариуцлага сул, сонгуулийн амлалтын үл биелэгдэх байдал;
4. Улс төрийн намуудын төлөвшөөгүй байдал, эрх мэдлийн төлөөх тэмцэл хуйвалдаан болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшөөгүй байдал;

5. Ард түмнийг төлөөлж байгаа улс төрчдийн ёс суртахуун, ард түмнээ төлөөлөх чадварыг дээшлүүлэх, улс төрийн намуудын ард түмнийг төлөөлөх боловсон хүчнээ сонгох асуудлыг боловсронгуй болгох, сонгогчдын улс төрийн боловсрол, төлөөллийн ардчиллын тухай мэдлэгийг дээшлүүлэх;
6. Монголд төлөөллийн ардчиллын тулгуур зарчим болох мэдээллийн ил тод байдал, шударга үнэн байх зарчим алдагдсан мөн улс төрийн намын ард иргэдийн эрх ашгийг хамгаалах, нэгтгэх, соён гэгээрүүлэх үүрэг алдагдсан. Өөрөөр хэлбэл, улс төрийн намын төлөвшил сул байна
7. Хамтран ажиллаж, харилцан зөвшилцөх, буулт хийх чадвар алдагдсан;
8. Хүнд суртал;
9. Хоёр танхимтай парламенттай болох гэх мэт.

Төлөөллийн ардчилал гэдэг нь иргэд өөрийнхөө өмнөөс үүрэг хүлээсэн хэн нэг албан тушаалтныг сонгож, түүгээрээ дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх хэлбэрийг хэлнэ. Иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах, ард түмний тусын тулд зохих хөтөлбөрийг биелүүлэх үүрэг бүхийн албан тушаалтныг сонгож түүгээр дамжуулан төрийн хэрэгт оролцох иргэдийн улс төрийн оролцоо юм.

Шинжээчдийн өгсөн саналаас гадна төлөөллийн ардчиллын талаарх гажуудал, бэрхшээлийн талаар судалгаанд оролцогчдын нэрлэсэн бусад зүйлсийг нэгтгэн үзэж дараах байдлаар бүлэглэн авч үзвэл. (Хүснэгт №1).

Хүснэгт 1.


Төлөөллийн ардчилалд учирч буй бэрхшээлүүд (бүлэг, зүйл, хувь)

№	Бүлэг, зүйл	Хувь
1	<i>Улс төрийн намтай холбоотой</i>	
	<ul style="list-style-type: none"> <li>• Намын харьяалалаас болж шийдвэрт нөлөөлөх чадваргүй</li> <li>• Намууд төлөвшөөгүй</li> </ul>	9.4 5.7
2	<i>Улс төрчидтэй холбоотой</i>	
	<ul style="list-style-type: none"> <li>• Улс төрчдийн ёс суртахуун</li> <li>• Популизм</li> </ul>	5.7 5.7
3	<i>Төр засагтай хобоотой</i>	
	• Төлөөллийн ардчиллын үндсэн зарчим алдагдсан	5.7
	• Мэргэшсэн байнгын үйл ажиллагаатай, судалгаанд тулгуурласан аппарат	5.7
	• Төлөөллийн болон зөвлөлдөх ардчилал хослуулах	3.8
	• 2 танхимтай парламент, улс төрийн тогтолцоо өөрчлөх	3.8
• Төлөөлөх чадваргүй боловсон хүчин төр их байна	1.9	
4	<i>Сонгогчтой холбоотой</i>	
	• Сонгогчдоо төлөөлж чадахгүй	9.4
	• Сонгуулийн тогтолцоо өөрчлөх	3.8
• Хариуцлагагүй сонголт	1.9	
5	<i>Хариуцлагын тогтолцоотой холбоотой</i>	
	<ul style="list-style-type: none"> <li>• Хариуцлага тооцох механизм үгүйлэгдэж байна, иргэдийн хяналт сул</li> <li>• Иргэний нийгэмтөлөвшөөгүй</li> </ul>	18.9 1.9
6	<i>Хууль, эрх зүйтэй холбоотой</i>	
	<ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн хуулийн заалтыг өөрчлөх</li> <li>• Гайгүй, ердөө л анхдагч хуулиа сайжруулах</li> </ul>	5.7 1.9
7	<i>Бусад</i>	
	• Улс төрийн боловсрол сул	5.7
	• Мэдээллийн ил тод байдал, шударга үнэн байх зарчим алдагдсан	1.9
• Мөнгөний нөлөө их	1.9	

Дээрх бүлгүүдээс харахад төр засгийн бодлоготой холбоотой бүлэг нь шинжээчдийн саналын дийлэх 20.9 хувийг эзэлж 1-рт эрэмбэлэгдэж байгаа бол 2-рт 20.8 хувиар хариуцлагын тогтолцоотой холбоотой асуудал, 3-рт 15.1 хувиар улс төрийн намтай холбоотой мөн сонгогчтой холбоотой асуудлууд байна. Харин 4-рт улс төрчидтэй холбоотой асуудал 11.4 хувь, 5-рт бусад асуудал 9.5 хувь, 6-рт хууль, эрх зүйтэй

холбоотой асуудал 7.6 хувьтай байна. Эндээс дүгнэн үзвэл ерөнхийдөө төр засагийн бодлого, хариушлагын тогтолцоо, улс төрийн нам, сонгогчдын талаарх асуудлууд бидний өнөөгийн нийгэмд тулгараад буй нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих бэрхшээлүүд байна гэсэн үг юм. Бүлэг тус бүрийн хувийг график №1-ээс харвал дараах дүр зураг харагдаж байна.

График №1. Бүлэг тус бүр (хувь)



Харин төлөөллийн ардчилалд учирч буй асуудал, бэрхшээл, гажуудлын талаар шинжээчдийн өгсөн саналуудыг харьцуулан давтамжаар нь эрэмбэд хуваан авч үзвэл. Үүнд:

1-рт, Хариуцлага тооцох механизм үгүйлэгдэж байна, иргэдийн хяналт сул гэсэн асуудал 18.9 хувь

2-рт, Сонгогчдоо төлөөлж чадахгүй, намын харьяалалаас болж шийдвэрт нөлөөлөх чадваргүй зэрэг асуудал тус бүр 9.4 хувь

3-рт, Намууд төлөвшөөгүй, улс төрчдийн ёс суртахуун, популизм, төлөөллийн ардчиллын үндсэн зарчим алдагдсан, мэргэшсэн байнгын үйл ажиллагаатай, судалгаанд тулгуурласан аппарат, улс төрийн боловсрол сул зэрэг асуудлууд 5.7 хувьтай байна.

2015 оны 1 дүгээр сарын 23-нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Швейцарийн Хөгжлийн агентлаг хамтран “Монгол Улсад төлөөллийн болон шууд ардчилалыг хослуулан хэрэгжүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэгт Профессор Андреас Ауэр Монгол Улсад зохион байгуулагдсан төлөөллийн ардчилал, шууд ардчилал нь нэгэн зэрэг хэрэгжих боломжтой систем гэдгийг дараах байдлаар тайлбарлалсан байдаг. “Иргэд хуулийн дагуу өөрийнхөө төлөөллийг төрд сонгож төлөөллийн ардчиллыг бүрдүүлдэг. Үүний арга нь сонгууль юм. Олон хүн төлөөллөө болгож цөөн хүнийг төрд буюу парламентад сонгодог. Сонгосон болон сонгогдсон хүмүүс хоорондоо бодитойгоор гэрээ байгуулдаггүй. Хоорондын холбоо нь зохиомол. Харин шууд ардчиллын хувьд хүмүүст саналаа шууд өгөх боломжийг олгодог. Төлөөллийн ардчиллын гол элемент нь сонгууль байдаг бол шууд ардчиллын гол элемент нь санал асуулга юм. Хүмүүсийн олонхийн өгсөн саналаар асуудлыг шийддэг. Санал асуулгыг Үндсэн хууль болон бусад хуульд өөрчлөлт оруулах, захиргааны түвшний шийдвэр гаргах, төсөвтэй холбоотой асуудал шийдэхэд ашиглаж болно. Санал асуулгыг үндэсний хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж болно. Мөн гарын үсэг цуглуулах маягаар явуулж болно” хэмээн тайлбарласан байна. Энэ байдлаас хархад Монгол Улсад төлөөллийн ардчилал болон шууд ардчилал нь дангаараа хөгжих боломж хомс, бие биенээ дэмжиж хөгжих нь илүү боломжтой гэж харагдаж байна. Энэ нь манай судалгаагаар нотлогдоод байна. Тухайлбал, судалгаанд оролцсон шинжээчдын дунд “Хэрэв төлөөллийн болон шууд ардчилал хослох тохиолдолд тэдгээрийн ямар хувилбар нь илүү зохимжтой вэ” гэсэн асуултанд төлөөллийн ардчилал зонхилсон хувилбар гэж 35.0 хувь, шууд ардчилал зонхилсон хувилбар гэж 5.0 хувь хариулсан бол төв засаглалдаа төлөөллийн ардчилал зонхилсон, орон нутагт шууд ардчилал голлосон хувилбар гэж 55.0 хувь нь хариулсан байна. Энэ нь дээрх дүгнэлтийг батлаж буй нэгэн нотолгоо юм.

Гэвч шууд ардчилал болон төлөөллийн ардчилалд учирч буй асуудал, бэрхшээл, гажуудалууд байгаа боловч энэ нь өөр хоорондоо харилцан адилгүй юм. Тухайлбал, өнөөгийн байдлаар шууд ардчилал нь манай улсад хэлбэр төдий байна, иргэдийн улс төрийн оролцоо сул байгаа үед зохимж муутай байна, оролцооны эцсийн үр дүн гардаггүй, шууд ардчилалаар шийддэг асуудал нь бага, баг хорооны түвшинд шийддэг асуудал бага, шууд ардчиллын хэлбэрүүд хэрэгжих эрх зүйн орчин сул, иргэний нийгмийн байгуулал, байгууллага хөгжөөгүй, иргэдийн оролцоог идэвхижүүлэх механизм сул, нам дагасан улс төрийн оролцооны идэвхижилт их, эмх замбараагүй, зохицуулалтгүй жагсаал цуглаан, зарим талаар эмх цэгц дэг журамгүй байдал нь нийгмийн анарх байдалд хүргэх аюултай, иргэний мэдлэг боловсролын дутмаг байдал, иргэдийн идэвх санаачлага сул, иргэний оролцоог дэмжиж урамшуулах механизм байхгүй, намаараа талцах байдал их, Орон нутгийн сонгуулийн доод түвшинд намууд оролцохгүй байх, шууд ардчиллыг төлөвшүүлэхэдээ мэдээлэл технологийн боломжийг ашиглаж шууд ардчиллыг боловсронгуй болгох, хэвлэл мэдээлэл эрх баригчдад

үйлчилдэг учраас шууд ардчилал хумигдсан, нийгэмд эдийн засгийн ялгарал хэт их болж дундаж давхарга үгүй болж байгаа учраас шууд ардчиллын боломж үгүй болж байна.

Мөн улс төрийн намуудын шийдвэр гаргах, зөвшилцөх чадвар сул, улс төрийн намуудын үзэл суртал, бодлогоороо ялгарах чадамжгүй байдал, иргэдийн улс төрд оролцох, мөн хяналтын механизм муу, иргэдийн улс төрд оролцох суурь нийгмийн хамгааллын эрх чөлөө, тэгш байдлын баталгаа хангагдаагүй, ядуурал байгаа нь эдийн засгийн шууд хамаарлыг бий болгож байна гэх мэт шууд ардчилалд учирч буй бэрхшээлтэй, гажуудсан асуудал их байна.

Харин шинжээчдийн дунд явуулсан санал асуулгын дүнгээс харахад шууд ардчилалд бэрхшээлтэй дараах асуудал байна гэж үзэв. Үүнийг хувиар нь жагсааж үзвэл.

#### Шууд ардчилалд учир буй бэрхшээлүүд (хувь)

№	Бэрхшээл	хувь
1	Иргэдийн боловсрол дутмаг, нийгмийн ухамсар	28.2
2	Эрх зүйн орчин бүрдүүлэх	10.3
3	Хувь хүний идэвхийг дээшлүүлэх, оролцоо сул	7.7
	Улс төрд оролцох механизм муу	7.7
	Орон нутгийн сонгуульд зарим намуудын оролцоо муу байна	7.7
	Баг, хорооны санхүүжилт муу	7.7
4	Нам дагах улс төрийн оролцоо сул	5.1
	Хэсэг бүлэглэл давуу эрхтэй учир	5.1
5	Хэлбэр төдий, манайд тохирохгүй	2.6
	Эрх баригчид мэдээлэлд хяналт тогтоодог	2.6
	Нийгмийн ялгарал	2.6
	Непотизм	2.6
	Улс төрийн намуудын зөвшилцөл муу	2.6
	Нийгмийн анархи, жагсаал цуглаан	2.6

Манай улсын ардчиллын хөгжилд нэгэн томоохон онгорхой орон зай үлдсэн нь сүүлийн үед яригдах болсон шууд ардчилал хэмээх ойлголт юм. Өөрт хамгийн ойр, өөрийнхөө эрх ашигт хамгийн түрүүнд үйлчилдэг асуудлуудаар өөртэйгөө ижил хүмүүсийн хамт өөрийнхөө амьдран сууж буй газар нутгийн хэмжээнд хамтран шийдвэр гаргаж, гаргасан шийдвэрээ хамтран хэрэгжүүлдэг ардчилсан механизмийг л шууд ардчилал гэнэ. Шууд ардчилалд учирч буй гажуудал, бэрхшээлтэй асуудлын гол цөм нь иргэдийн улс төрийн оролцоо юм.

**Монгол дахь ардчилал улам боловсронгуй болж, сайжрах үе шатандаа явж байна гэж шинжээчдийн олонх нь дүгнэсэн байна. Иймээс бид цаашид ардчиллыг хэрхэн төгөлдөржүүлэх боломж, гарц шийдлийн талаар судлан дүгнэх нь зүйн хэрэг. Төлөөллийн ба шууд ардчиллыг төгөлдөржүүлэх боломж, гарц, шийдлийн талаар дараах асуудлыг шинжээчдийн санал асуулгын дүнд үндэслэн тавьж байна. Үүнд:**

- Үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооны доголдлыг арилгах;
- Иргэдийн улс төрийн боловсрол, соёлыг нэмэгдүүлэх;
- Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;
- Хувийн өмчийн халдашгүй дархан байдлыг төрөөс хангаж өгөх;
- Улс төрийн намын нийгмийн хариуцлага болон имижийг нь өсгөх, нэмэгдүүлэх;
- Улс төрчдийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг сайжруулах мөн имижийг нь өсөх;
- Сонгуулийн тогтолцоог сонгогчдод ашиг тустай байдлаар өөрчлөх;
- Авлига, хээл хахуулийг багасгах, арилгах;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн бие даасан хараат бус байдлыг хангах;
- Шүүх, цагдаа, хүчний байгууллагын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, хяналтыг сайжруулах;
- Жижиг дунд үйлдвэрийг төрөөс дэмжих;
- Уул уурхай, байгалийн баялгийг иргэдийн оролцоотой хянах, шийдвэрлэх зэрэг боломжийг ашиглан гарц, шийдлийг шийдэж болох юм.

Тус судалгаанд оролцсон шинжээчдийн олонхи нь ардчиллыг төгөлдөржүүлэх, боломж, гарц шийдэл нь нэгдүгээрт, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн бие даасан хараат бус байдлыг хангах, хоёрдугаарт, улс төрийн намын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, гуравдугаарт, авлига, хээл хахуулийг арилгах, дөрөвдүгээрт, улс төрчдийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг сайжруулах, тавдугаарт, шүүх,

цагдаа, хүчний байгууллагын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, хяналтыг сайжруулах шаардлагатай хэмээн үзжээ.

**Abstract:** The common form of democracy such accepted by humans that regards to direct and representative democracy. In the reason human lives, that those forms are democratic connections with mutually complement to each other in a good challenges. According to the realities of Mongolian cases, those processes of democratic reform and its implementation such performs that reform process in 1990, has lost by ratio of both types of democracy such as direct and representative democracy in order to rather comes through understanding of democracy and its proper form. But the consequences of citizens' political participation including representative and direct democracy's advantages and benefits disappearing eliminated to a negative effect on democracy as well as.

Thus, the Department of Political Studies at the Institute of Philosophy from Academy of Sciences has been performed that themed basic research project on "*Representative Democracy and citizens' participation in Mongolia*" in order to conduct that expert survey with a comprehensive review for this circumstances.

Within this topic, we attempted to review on the crucial matter of democracy opportunities and challenges.

### НОМ ЗҮЙ:

1. Ш.Батсүх, Я.Долгоржав, Б.Ганцоож нар. Шууд ардчилал-иргэдийн оролцоо. Удирдлагын академи. УБ., 2014.
2. Даль А.Роберт. Ардчиллын тухай. Орч: Д.Ганхуяг, Ч.Энхбат нар. УБ., 2005.
3. Үндсэн хууль ба зөвлөлдөх ардчилал. Онол практикийн бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2015.
4. ФСЭХ. Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ. УБ., 2006.
5. ФСЭХ. Монголын ардчиллын төлөвшил. Хамтын бүтээл. УБ., 2011.
6. ФХ. Философи, эрхийн судлал-XXXI. Эрдэм шинжилгээний цуврал. УБ., 2016.
7. ФХ. Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо. Социологийн судалгааны тайлан. УБ., 2017.
8. О.Хатанболд. Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс. Улс төрийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилж бичсэн нэг сэдэвт бүтээл. УБ., 2016.